



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн
ЗАРЛИГ

1974 оны 1 дугаар сарын 7 өдөр. Дугаар 02
Улаанбаатар хот

ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс
Т О Г Т О О Х НБ:

1. Төв аймгийн Гацуурт сумыг хороо болгон өөрчлөн байгуулж, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд харьяалуулсугай.
2. Гацууртын сангийн аж ахуйн эзэмшилд байгаа газрыг хавсралт ёсоор Төв аймгийн Батсүмбэр сумын нутгийн хилийн цэст оруулан баталсугай.
3. Гацуурт сумын нутгийг мөн сангийн аж ахуйн эдэлбэр газар болгон хэвээр ашиглуулж байхыг Хөдөө аж ахуйн яам, Төв аймгийн гүйцэтгэх захиргаанд даалгасугай.
4. Энэ зарлиг гарсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 142 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын 250-аар баталсан Батсүмбэр сумын нутгийн хилийн цэсийг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн дарга

БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн 1-р орлогч дарга

БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн орлогч дарга

БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн
дарга

Тэргүүлэгч гишүүн:

(С. ЛУВСАН)

(Ц. ДҮГЭРСҮРЭН)

(Ц. ГОТОВ)

(С. БАТАА)

(Д. ЕНДОНДҮЙЧИР)

(Н. ЛУВСАНРАВДАН)

(Г. ОЧИРБАТ)

(С. УДВАЛ)

(С. ПҮРЭВЖАВ)

(Д. ЯДАМСҮРЭН)